



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар E/17

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Хориг тавих тухай

Монгол Улсын Их Хурал 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийг дагалдах хуулиудын хамт баталж, 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт ёсчлон ирүүлсэнтэй танилцлаа.

Дэлхий дахинд тархаад байгаа коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал дотоодод алдагдаж, нөхцөл байдал 2021 оны төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байх үеэс эрс хүндэрч, цар тахал улс орон, ард иргэдийн амьдралыг орвонгоор нь өөрчилж мэдэх эгзэгтэй, хүнд цаг үе тулгарч байна.

Ийм нөхцөлд иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалах шинжлэх ухаанч цогц төлөвлөгөөтэй, бэлтгэгдсэн бүтэцтэй, эдийн засгийн бааз сууриа эрсдүүлэхгүйн тулд бизнес, аж ахуйгаа дампууруулахгүйгээр авч үлдэх, ажил орлоготой иргэдийнхээ орлогыг, амьдралын түвшин доогуур иргэдийнхээ амьжиргааг эрсдэлээс хамгаалж, гамшгийн дараах улс орны эдийн засгийг сэргээн босгох нь иргэндээ ээлтэй төрийн үндсэн үүрэг байх ёстой.

2020 оны төсөв Улсын Их Хурлын ээлжит сонгуульд зориулагдсан, татвар төлөгчдийн мөнгийг гишүүдийн тойрогт авлига мэтээр хуваарилсан, хэтэрхий өндөр зарлагатай, тухайн зарлагадаа тохируулж үндэслэл муутай, бүрдэхээргүй хийсвэр орлогыг ихээр төлөвлөсөн, төсвийн алдагдлыг улам нэмэгдүүлсэн зэрэг улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд хүндрэл учруулах олон дутагдалтай, алдаа ихтэй, эрсдэл бүхий төсөв болсныг тухайн төсвийг хэлэлцэх үед нь шүүмжлэн хориг тавьж байсан. Үүний дараа дэлхийн улс орнууд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалд нэрвэгдэж эхэлсэнтэй уялдуулан миний бие 2020 оны төсөвт тодотгол хийж, тэвчиж болох бүх зардлыг танах, хямралын эсрэг тусгай сан байгуулах, уг санд

2020000103

төвлөрсөн хөрөнгийг оновчтой зөв бодлого, арга хэмжээнд нээлттэй, ил тод, хяналттай зарцуулах уриалгыг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр гаргасан.

Харамсалтай нь Сангийн сайдын төсөвт тодотгол хийхгүй хэмээх муйхар хорон мэдэгдэл сонгууль дуустал үргэлжилж, сонгуулийн дараагаас бодит байдал хөрсөн дээрээ бууж, үнэнд гүйцэгдмэгц 8 дугаар сард 4.8 их наяд төгрөгийн алдагдалтай, ганцхан жилийн дотор 1.7 тэрбум орчим ам.долларын өр үйлдвэрлэхээс өөр аргагүй нөхцөл байдалд улс орноо оруулсан, эрх мэдэл, албан тушаалдаа үлдэх сонгуулийн явцуу зорилгод нийцсэн төсвийн тодотголыг баталсан.

Миний бие энэхүү хариуцлагагүй төсвийн тодотголыг хүлээн зөвшөөрөх аргагүй байсан хэдий ч хориг тавьсан тохиолдолд цар тахалтай холбогдсон хорио цээрийн дэглэм, хязгаарлалтаас үйл ажиллагаа нь доголдож, хүндэрсэн иргэн, аж ахуйн нэгжүүдэд төрийн байгууллагуудын зүгээс улс төрийн зорилго бүхий хүндрэл бэрхшээл учруулж болзошгүйг харгалзан 2021 оны төсвөөр алдаа, завхралаа засахыг зохих түвшинд нь анхааруулан мэдэгдэж өнгөрсөн.

Гэвч 2021 оны улсын төсөв бидний тавьсан шаардлагад огт нийцээгүй төдийгүй, төсвийн урсгал ба хөрөнгө оруулалтын зардалд хатуу шалгуурыг тогтоон, үрэлгэн байдлыг бүрэн халж чадсангүй. Улсын болон дэлхийн эдийн засагт үүсээд байгаа нөхцөл байдлыг олон талаас нь бодитойгоор дүгнэж, төсвийн бодлогод тусгах ёстой байтал огт тоосонгүй. Тухайлбал, эрхэм гишүүд та бүхэн ард иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалахад амин чухлаар хүлээгдэж байгаа вакцины тухай мэдсээр байж гарсан даруйд нь худалдаж авах хөрөнгийг төсөвт тусгалгүй, гадны зээл тусламжаар шийдвэрлэнэ гэсэн хоосон мөрөөдөлд хөтлөгдөн, улсын төсвийн бодлогод хүйтэн хөндий, сэтгэлгүй хандсан нь дэндүү хариуцлагагүй үйлдэл мөн. Тиймээс 2021 оны улсын төсөвт дараах бодлогын хүрээнд зохих өөрчлөлтүүдийг хийх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Төсвийн нийт зардлыг 20 хувиар хэмнэж, хүндрэл бэрхшээлийг даван туулахад зориулсан эрсдэлийн сан байгуулах,

Хоёрдугаарт, Эрсдэлийн сангаас өрх бүрд нэг сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг боловсруулж, дотоод нөөц бололцоогоо бүрэн ашиглаж нэн даруй хэрэгжүүлэх, ингэхдээ 200,000 төгрөгийг бэлнээр олгож, үлдсэн 800,000 төгрөгийг зөвхөн үндэсний үйлдвэрлэгчээс архи, согтууруулах ундаа, тамхины төрлөөс бусад бараа, бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг /ваучер/-ээр олгох,

Гуравдугаарт, Төсвийн хэмнэлтээр бий болсон хөрөнгийн тодорхой хувийг коронавирусын эсрэг вакцин худалдаж авахад зарцуулах,

Дөрөвдүгээрт, Үйлдвэр, аж ахуйн нэгж, бизнесийг дэмжсэн мастер төлөвлөгөө гаргах, үүний хүрээнд жижиг дунд үйлдвэр эрхлэгчид болон өдрийн орлоготой, түүгээрээ амьдардаг үсчин, оёдолчин, дархан, мужаан, такси зэрэг ажил, үйлчилгээ эрхэлдэг иргэдийг онцгой анхаарсан бодлого хэрэгжүүлэх.

Эдгээр зорилтыг хангахын тулд төсөвт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсэж байгаа учраас Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан хуулиудад бүхэлд нь хориг тавьж байна.

Хоригийг зохих хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА